

“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ

Хамрах хугацаа: 2023/04/01-2023/06/30

2023оны 06 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Хаанаас (Хэнээс) ирүүлсэн	Хүлээн авсан он, сар, өдөр	Агуулга	Шилжүүлсэн газар, алба, ажилтан	Хэрхэн шийдвэрлэсэн	Хариу өгсөн хэлбэр (он, сар, өдөр, амаар болон бичгээр)	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1	Г.Ганцэцэг	2023.04.04	БЗД-ийн 8-р хороо, Гарден резиденс хотхоны 75а байрны нэг цахилгаан шат нь 16-15 давхар руу унадаг. Нэг нь 24 цаг ажиллаад элэгдэл, хорогдол их байна. 75б байрны цахилгаан шат нь мөн байнга асуудалтай байдаг. Холбогдох газарт нь уламжилж шалгаж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	БЗД-ийн 8 дугаар хорооны Гарден резиденс хотхоны 75а байрны цахилгаан шатны дээд төгсгөлийн таслагчийн ролик элэгдсэн байсныг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан бөгөөд одоогийн байдлаар хэвийн ажиллаж байна. Тус лифтний засвар, техник үйлчилгээг "Ти Би Жи" ХХК хариуцан ажиллаж байна.	2023.04.12, амаар (утсаар мэдээлэл өгсөн)	
2	Л.Шийтэр	2023.04.26	БГД-ийн 5-р хорооны 8-р байрны цахилгаан шатыг сольсон юм. Ашиглалтад оруулах тал дээр яаравчилж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж байгаа Баянгол дүүргийн 5 дугаар хорооны 8 дугаар байрны 1 дүгээр орцны цахилгаан шатны ажлыг "Оакс экспресс монголиа" ХХК нь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан. "Оакс экспресс монголиа" ХХК нь тус гэрээт ажлаар 10 цахилгаан шат шинэчилж байгаа бөгөөд лифтнүүдэд бүрэн	2023.04.28, амаар (утсаар мэдээлэл өгсөн)	

					магадлал хийлгэх албан хүсэлтийг Хотын стандарт, хяналтын газарт 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хүргүүлсэн. Тус лифтэнд бүрэн магадлал хийж акт баталгаажсаны дараа улсын комисс хүлээн авч, байнгын ашиглалтад оруулах болно.		
3	Ц.Бямбапүрэв	2023.05.01	ХУД-ийн 11-р хорооны "Time Square" хотхоны 511-р байрны цахилгаан шат дээд давхраас доошоо алдаад байна. Энэ үзэгдэл хэд хэдэн удаа давтагдаж байна. Хүн унаж эрсэдвэл хэн хариуцлага хүлээх вэ? Энэ асуудлыг холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, хяналтын инженер Ц.Уранбилэг	ХУД-ийн 11 дүгээр хороонд байрлах "Time Square" хотхоны цахилгаан шатуудын засвар, техник үйлчилгээг "Номин трейдинг" ХХК хариуцан ажилладаг байна. Тус хотхоны 511 дүгээр байрны лифтний хувьд хонгилын хаалганы тохиргоо алдагдаж лифт доошоо алдаж огцом зогсоод байсан гэмтлийг тогтоож, 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр "Номин трейдинг" ХХК засварлан хэвийн ажиллагаанд оруулсан байна.	2023.05.09, амаар (утсаар мэдээлэл өгсөн)	
4	Н.Болормаа	2023.06.12	БЗД-ийн 25 дугаар хороонд байрлах өндөр 39 дүгээр байрны лифт нь маш муу байнга гацдаг, эвдэрдэг хуучны энэ лифтийг солиулах хүсэлт гаргаж байна. Холбогдох байгууллагад нь уламжлан шийдвэрлэж өгнө үү.	Инженер техникийн хэсэг, Ерөнхий инженер М.Энхбат	БЗД-ийн 25-р хорооны 39 дугаар байрны 2 лифт Беларусийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар шинэчлэгдэх 132 лифтний жагсаалтанд орсон байна. Мөн "Өндөр -39" СӨХ-ийн гүйцэтгэх захирал Н.Эрдэнэцэцэг болон хүсэлт гаргагч иргэн Н.Болормаатай уулзаж нөхцөл байдлыг танилцуулсан. 2023 оны төсвийн тодотголд 20 лифт шинэчлэх жагсаалт болон хөрөнгийн эх үүсвэрийг шийдэж өгөх хүсэлтийг хүргүүлсэн. Тухайн байрны лифт нь энэхүү жагсаалтанд орсон болно.	2023.06.19 амаар (утсаар мэдээлэл өгсөн)	